

ハロー！ジャパン

HELLO! JAPAN

Япон Улсын Гадаад хэргийн яам

<http://www.mofa.go.jp/>  
<http://www.web-japan.org/>

Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам


<http://www.mn.emb-japan.go.jp>





## Гарчиг

- P.02 Эзэн Хааны гэр бүл, Төрийн далбаа, Төрийн дуулал
- P.03 Газар зүй, Байгаль
- P.05 Хотын амьдрал
- P.07 Хувцас, Хоол хүнс, Орон байр
- P.09 Сургуулийн амьдрал
- P.11 Япон хэл
- P.13 Баяр ёслол
- P.15 Соёл
- P.17 Спорт
- P.19 Түүх
- P.21 Төр засгийн тогтолцоо, Олон улсын харилцаа
- P.23 Эдийн засаг, Аж үйлдвэр, Техник технологи
- P.25 Байгаль орчны хамгаалал



Сакура  
14 настай

Юүта  
11 настай



# Эзэн Хааны гэр бүл, Төрийн далбаа, Төрийн дуулал



Сакура

Юүта

Япон улсын Үндсэн хуульд Эзэн Хаан бол Япон улсын бэлгэ тэмдэг хэмээн заасан байдаг. Төрийн далбаа нь цагаан дэвсгэр дээр гал улаан нарны дугуй дүрстэй, төрийн дуулал нь “Кимигаё” хэмээх дуу болно.

## Эзэн Хаан ба түүний гэр бүл

Одоогийн Эзэн Хаан нь 1989 онд 125 дахь Эзэн Хаанаар өргөмжлөгдсөн. Эзэн Хаан нь дотоодод зохион байгуулагдах төрөл бүрийн арга хэмжээнд оролцох, байгалийн гамшигт өртсөн бүс нутагт очиж ард иргэдийг эргэх, олон улсын найрсаг харилцааг гүнзгийрүүлэх зэрэг албан үүргээ гүйцэтгэхээс гадна, Японы уламжлалт соёлыг хамгаалах, эрдэм шинжилгээний ажилд ч мөн оролцдог.



## Төрийн далбаа

Япон улсын төрийн далбааг албан ёсоор “Нишшооки” буюу “Нарны далбаа” хэмээн нэрлэдэг бөгөөд энгийн хэллэгээр “Хиномарү” буюу “Нарны дугуй” хэмээнэ. Далбааны улаан дугуй нь нарыг бэлгэддэг.



## Төрийн дуулал

Япон улсын төрийн дуулал нь “Кимигаё” юм. Эрт үед бичигдсэн шүлгийн үгэнд 19-р зууны сүүл үед аялгууг нь зохиосон. Дууны үг нь “Жижигхэн чулуу олон жилийн явцад том хад болж, тийнхүү хөвд ургадгийн адил дэлхий ертөнц урт удаан цэцэглэн мандах болтугай” гэсэн утгатай.


君が代  
Kimi Ga Yo  
古 巖  
林 正守 作曲  
Trad. arr. Hiromari Hayashi






# Газар зүй, Байгаль

Япон улс далайгаар хүрээлэгдсэн, урдаас хойш сунаж тогтсон арлын улс юм. Хагас арктикийн бүсээс дулаан бүс, цаашлаад хагас тропикийн бүс хүртэл уур амьсгалын ялгаа болон газарзүйн элдэв онцлог нь жилийн дөрвөн улирал, үзэсгэлэнтэй байгалийг бүрдүүлдэг.




## Шинано гол

Нийт 367км-ийн урттай Японы хамгийн урт гол. Японы гол мөрний ихэнх нь түргэн урсацтай, усаар баялаг байдаг тул усан цахилгаан станц болон усан тээврийг ихээр ашигладаг. Шинано голын дагуух сав газар нь уудам сайхан байгальтай бөгөөд тэнд завиар зугаалж, мөн загас барьж амралтаа өнгөрөөх хүмүүс олонтаа таардаг.



## Бива нуур

Нийт 670 км<sup>2</sup> талбайтай Японы хамгийн том нуур. Японы газар бүрт том жижиг нуурууд байдаг. Бива нуур нь аялал жуулчлалын төвийн нэг бөгөөд завь болон усны цана зэрэг усан спортоор наадан амралтын цагаа өнгөрөөх боломжтой.



Газар нутаг : 378,000 км<sup>2</sup> орчим  
Хүн ам : 128 сая орчим  
Зүүнээс баруун хүртэл : 3,000 км орчим  
Өмнөөс хойд хүртэл : 3,000 км орчим  
Далайн эргийн урт : 34,000 км орчим  
Японы нутаг дэвсгэрийн дөрөвний гурав нь уулархаг бүс бөгөөд голын ай сав газар, уул хоорондын хонхор газарт хот суурин газрууд хөгжиж, хүн ам төвлөрсөн байдаг. Температур нь харьцангуй бага хэлбэлздэг ч зуны эхээр сар хагасын хугацаанд борооны улирал үргэлжлэх ба өвлийн цагт цас ордог.



## Күширогийн намагшсан газар

Ойролцоогоор 18,300 га талбай бүхий Японы хамгийн том намагшсан газар. Японы намагшсан газруудад ховор ан амьтан болон ургамал байдаг. Күширогийн намагшсан газрын ус маш тунгалаг бөгөөд уг газраар урсах голыг завиар уруудан сайхан байгалийг үзэх боломжтой.



## Фүжи уул

Далайн түвшнээс 3,776 метрийн өндөрт сүндэрлэсэн Японы хамгийн өндөр уул. Япон галт уул олонтой бөгөөд хамгийн сүүлд 300-н жилийн өмнө дэлбэрсэн Фүжи уул ч мөн идэвхтэй галт уулуудын нэг юм. Конус хэлбэрт энэ сайхан уулын оргилоос нар мандахыг харахаар олон хүн Фүжи ууланд авирдаг.

## Минамитори арал





# Хотын амьдрал

Япон даяар хотууд хөгжсөн бөгөөд 1 саяас дээш хүн амтай 12 хот байдаг. Зам харилцаа хөгжсөн, захиргааны байгууллага, худалдааны гудамж болон соёлын байгууламжууд төвлөрсөн байдаг тул амьдрахад нэлээд тухтай.



Японы хотууд дэлхийн II-р дайны дараахи эдийн засгийн хурдацтай өсөлтийн үед хөгжсөн. Хотод ажиллах хүмүүсийн тоо олширч, том том хотуудын ойролцоо дагуул хотууд бий болсон. Хүмүүс хөдөө орон нутгаас хот руу нүүж төвлөрөн, орон нутгийн хүн ам нэлээд сийрэгжсэн ч автомашинтай бол амьдрахад нэг их бэрхшээл байдаггүй тул тэтгэвэрт гарсны дараах амьдралаа хөдөө өнгөрүүлэх хүмүүсийн тоо нэмэгдэж байна.



**Миний амьдардаг хот**  
Том галт тэрэгний буудалтай, дагуул хотуудтай холбох метро болон автобусын сүлжээтэй. Буудлын ойролцоо худалдааны гудамжууд сайн хөгжсөн, тэдгээрийн эргэн тойронд амьдралд хэрэгтэй байгууламжууд ч мөн төвлөрсөн байдаг тул дөхөмтэй. Би хааяа хол газар аавынхаа машинаар явахаас бусад үед хот дотор явган явдаг.



Үйлдвэр



Шуудан



24 цагийн дэлгүүр

Жилийн турш 24 цаг ажилладаг. Тэнд банкны ATM байх бөгөөд нийтийн үйлчилгээний төлбөрөө тушаах боломжтой.



Эмнэлэг

Бөглөрлийн цаг

Төмөр замын сүлжээ хөгжсөн ч өглөө оройд хүмүүс ажил сургуульдаа ирж буцаад бөглөрөл ихтэй болдог.



Галт тэрэгний буудал




Орон сууц



Гал команд



Орон сууцны хороолол



Сургууль

Хотод байдаг бага сургуулиуд нь гэрээс алхаад очих зайд байрладаг. Гамшгийн үед хоргодох байр болдог.



Гэр бүлийн ресторан



Галт тэрэгний буудлын ойр хавьд Дэлгүүр болон ресторан, кино театр гэх мэт цагийг зугаатай өнгөрөөх байгууламжууд олон байдаг.



Кообан буюу цагдаагийн пост

Хотын гудамж бүрт байх цагдаагийн пост нь хотын аюулгүй байдлыг хангаж байдаг. Оршин суугчдад зам зааж өгөх, орхиж гээгдүүлсэн эд зүйлсийг нь эргүүлж өгөх зэрэг төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг.



Амины орон сууц




Хувийн Шуудан

Японы хаанаас ч маргааш нь ачаа хүргэж өгдөг хувийн шуудангийн систем хөгжсөн.



Цайз





# Хувцас, Хоол хүнс, Орон байр

Япон хүний амьдрал нь уламжлалт хэв маягаас Европын соёлыг шингээсэн холимог хэв маяг руу хувьсан ирсэн. Одоо ч хэвээрээ буй Японы уламжлалт хувцас, хоол хүнс, орон байрны онцлогийг энд танилцуулъя.



## Япон хүн болон Кимоно

Япончууд эрт үед “Кимоно”-г өдөр бүр өмсдөг байсан бол одоо европ хэв маягаар хувцасладаг болсон бөгөөд зөвхөн уламжлалт арга хэмжээ, баяр ёслолын үед л “Кимоно”-г өмсдөг. Мөн япон бүжиг бүжиглэх, цэцэг амьдруулах урлаг, цайны ёслол зэрэг Японы уламжлалт соёлын арга хэмжээний үеэр “Кимоно” өмсдөг.



Гутлаа тайлж гэртээ ордог.

## Японы орон байр

Хатаасан өвсөөр хийсэн Японы уламжлалт шалыг “Татами” гэдэг. Япончууд татами дээр шууд суудаг. Татамитай өрөөг зочны, хоолны, аль эсвэл унтлагын өрөө ч болгож болдог. Орчин үеийн сууц нь үндсэндээ европ хэв маягтай боловч, гэртээ орохдоо гутлаа тайлдаг заншилтай.



Хичээлийн өрөө



Япон ёсоор аягаа гартаа барьж савхаар иддэг.



## Япон хоол

Япончуудын гол хүнс бол агшаасан цагаан будаа бөгөөд үндсэн цэс нь цагаан будааг шөл болон хэд хэдэн төрлийн хоолыг хослуулсан иж бүрдэл юм. “Сүши”, “Тэмпура” нь хүүхдүүдийн дуртай хоол юм. Хөнгөн хоолонд “Онигири” буюу цагаан будааг иддэг.





# Сургуулийн амьдрал



Би өөрийнхөө сурдаг бага сургуулийнхаа амьдралаас танилцуулъя. Бага сургуульд 6 нас хүрсний дараа хавраас элсэн орж, 6 жил сурдаг. Хичээлээс гадуурх олон төрлийн үйл ажиллагаагаар дамжуулж олон зүйлийг сурч мэддэг.

## Спорт өдөрлөг

Жилд нэг удаа сургуулийнхаа талбайд спортын өдөрлөг зохиодог. Олон төрлийн тэмцээнээс гадна өөрсдийн дэглэсэн бүжгийг бүжиглэдэг. Гэр бүлийнхэн хүрэлцэн ирж хүүхдүүдээ дэмжин уухайлдаг.



**Нийгэмтэй танилцах аялал**  
Нийгмийн бүтэц, тогтолцооны ойлголтоо болохын тулд сургуулийн ойролцоох үйлдвэрүүдийг үзэж сонирхдог. Чихэр боов болон автомашиныг хэрхэн бүтээж байгааг бодитоор нь харж догдолцооно. Ангидаа сурч мэдэх боломжгүй зүйлсийн талаар тэндээс л олж мэднэ.

## Үдийн хоол

Сургуулиас бэлтгэсэн үдийн хоолыг бүгдээрээ иддэг. Хоол нь шим тэжээлтэй, өдөр бүр өөр өөр байдаг. Хоол тараах болон аяга таваг хураах ажлыг хүүхдүүд өөрсдөө ээлжээр хийдэг.



Бага сургуулиа төгсөөд дунд сургуульд 3 жил сурч ерөнхий боловсролтой болно. Түүний дараа элсэлтийн шалгалт өгч ахлах сургууль, их дээд сургууль болон мэргэжлийн сургуульд элсэх боломжтой. Одоогоор их сургуульд хоёр хүний нэг нь элсэн суралцаж байна.



## Аялал

Тогтуун цаг агаартай хавар намрын цагт байгальтай ойртож, түүхийн дурсгалт газруудыг үзэж сонирхох өдрийн аялалд явдаг. Ээжийнхээ бэлдсэн өдрийн хоолыг идэх нь ч сайхан байдаг шүү.



## Хичээл

Нэг ангид 30-40 хүүхэд хичээллэдэг. Эх хэл, математик, нийгэм, байгалийн ухаанаас гадна дуу хөгжим, дүрслэх урлаг, биеийн тамир, мөн англи хэл, хөдөлмөр гэх мэт хичээл заадаг. Гэрийн даалгавар өгөн, мөн ээлжит шалгалт авч сурлагын төвшин дээшилсэн эсэхийг шалгадаг.



Японы бага, дунд сургуулийн хичээлийн жил 4-р сард эхэлж, дараа жилийн 3-р сард дуусдаг. Энэ хооронд 1-р сар үргэлжлэх зуны амралт, жилийн эцэс ба эхээр өвлийн амралт, мөн хичээл эхлэхийн өмнө хаврын амралт байдаг. Элсэлтийн баяр 4-р сард, төгсөлтийн баяр ёслол 3-р сард болдог.





# Япон хэл

Япон хэл ханз, хирагана, катакана гэсэн 3 төрлийн үсгийг хольж хэрэглэдэг. Ханз нь 5-р зууны үед Хятадаас орж ирсэн. Хирагана, катакана нь ханзны хэлбэрийг өөрчлөн Японд бүтээсэн үсэг юм.

|  |   |  |   |  |       |
|--|---|--|---|--|-------|
|  | — |  | — |  | нар   |
|  | — |  | — |  | мод   |
|  | — |  | — |  | уул   |
|  | — |  | — |  | хүн   |
|  | — |  | — |  | шувуу |
|  | — |  | — |  | сар   |

## Ханз

Ханз нь юмсын хэлбэр дүрсийг дуурайлган бичсэн дүрснээс анх хөгжсөн боловч, орчин үед хэрэглэгддэг ихэнх ханз нь тухайн дүрсээ алдаад өөр хэлбэртэй болсон. Өдөр тутам хэрэглэгддэг 2,000 орчим ханз байдаг.




## Хирагана, Катаканагийн хүснэгт

Япон хэлэнд хирагана, катакана гэсэн 2 төрлийн үсэг байдаг. Хүснэгтийн дээрээс хирагана, катакана, мөн дуудлагыг бичлээ.

|   |    |     |     |    |    |    |    |    |    |    |    |    |    |    |
|---|----|-----|-----|----|----|----|----|----|----|----|----|----|----|----|
| あ | か  | さ   | た   | な  | は  | ま  | や  | ら  | わ  | が  | ざ  | だ  | ば  | ぱ  |
| ア | カ  | サ   | タ   | ナ  | ハ  | マ  | ヤ  | ラ  | ワ  | ガ  | ザ  | ダ  | バ  | パ  |
| a | ka | sa  | ta  | na | ha | ma | ya | ra | wa | ga | za | da | ba | pa |
| い | き  | し   | ち   | に  | ひ  | み  |    | り  |    | ぎ  | じ  | ぢ  | び  | ぴ  |
| イ | キ  | シ   | チ   | ニ  | ヒ  | ミ  |    | リ  |    | ギ  | ジ  | ヂ  | ビ  | ピ  |
| i | ki | shi | chi | ni | hi | mi |    | ri |    | gi | ji | ji | bi | pi |
| う | く  | す   | つ   | ぬ  | ふ  | む  | ゆ  | る  |    | ぐ  | ず  | づ  | ぶ  | ぷ  |
| ウ | ク  | ス   | ツ   | ヌ  | フ  | ム  | ユ  | ル  |    | グ  | ズ  | ヅ  | ブ  | プ  |
| u | ku | su  | tsu | nu | fu | mu | yu | ru |    | gu | zu | zu | bu | pu |
| え | け  | せ   | て   | ね  | へ  | め  |    | れ  |    | げ  | ぜ  | で  | べ  | ぺ  |
| エ | ケ  | セ   | テ   | ネ  | ヘ  | メ  |    | レ  |    | ゲ  | ゼ  | デ  | ベ  | ペ  |
| e | ke | se  | te  | ne | he | me |    | re |    | ge | ze | de | be | pe |
| お | こ  | そ   | と   | の  | ほ  | も  | よ  | ろ  | を  | ご  | ぞ  | ど  | ぼ  | ぽ  |
| オ | コ  | ソ   | ト   | ノ  | ホ  | モ  | ヨ  | ロ  | ヲ  | ゴ  | ゾ  | ド  | ボ  | ポ  |
| o | ko | so  | to  | no | ho | mo | yo | ro | wo | go | zo | do | bo | po |

|     |     |     |     |     |     |     |     |    |     |     |   |   |
|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|----|-----|-----|---|---|
| きゃ  | しゃ  | ちゃ  | にゃ  | ひゃ  | みゃ  | りゃ  | ぎゃ  | じゃ | びゃ  | ぴゃ  | あ | ア |
| キャ  | シャ  | チャ  | ニャ  | ヒャ  | ミャ  | リャ  | ギャ  | ジャ | ビャ  | ピャ  | ア | ア |
| kya | sha | cha | nya | hya | mya | rya | gya | ja | bya | pya | a | a |
| きゅ  | しゅ  | ちゅ  | にゅ  | ひゅ  | みゅ  | りゅ  | ぎゅ  | じゅ | びゅ  | ぴゅ  |   |   |
| キュ  | シュ  | チュ  | ニュ  | ヒュ  | ミュ  | リュ  | ギュ  | ジュ | ビュ  | ピュ  |   |   |
| kyu | shu | chu | nyu | hyu | myu | ryu | gyu | ju | byu | pyu |   |   |
| きょ  | しょ  | ちょ  | にょ  | ひょ  | みょ  | りょ  | ぎょ  | じょ | びょ  | ぴょ  |   |   |
| キョ  | ショ  | チョ  | ニョ  | ヒョ  | ミョ  | リョ  | ギョ  | ジョ | ビョ  | ピョ  |   |   |
| kyo | sho | cho | nyo | hyo | myo | ryo | gyo | jo | byo | pyo |   |   |

あ = хирагана  
ア = катакана  
a = уншлага



## 東京(とうきょう / TOKYO)

Галт тэрэгний буудлын нэрийг хүн бүр уншихын тулд ханз, хирагана, латин гэсэн 3 төрлийн үсгээр бичсэн байдаг.

## Катакана үсгээр бичдэг үгс

Гадаад орны газрын нэр, гадаад хүний нэр, гадаадаас орж ирсэн харь үгийг катакана үсгээр бичдэг.



タージ・マハル  
Таж Махал



ニューヨーク  
Нью-Йорк



シェークスピア  
Шекспир



クレオパトラ  
Клеопатра



チョコレート  
Шоколад



パスタ  
Паста

## Сакура

Хавар цэцэглэдэг Сакура бол Японы хамгийн алдартай цэцэг. Ханзаар “桜”, катаканагаар “サクラ” гэж бичдэг. Япон хэлийг хөндлөн мөн босоо бичдэг.

Конничива  
/Сайн уу/

Аригатоо  
/Баярлалаа/

Саёнара  
/Баяртай/



# Баяр ёслол

Япон нь жилийн дөрвөн улиралтай бөгөөд байгаль ч мөн өөрчлөгдөж үзэсгэлэнтэй болдог. Улирал бүр эртнээс уламжлагдан ирсэн баяр ёслолын арга хэмжээнүүд зохион байгуулагдаж, хүүхэд хөгшидгүй хөгжилтэй өнгөрөөдөг.



## Хөвгүүдийн баяр

Энэхүү баярыг эрэгтэй хүүхдийн өсөлтийг хүсэн ерөөж 5-р сарын 5-ны өдөр тэмдэглэдэг юм. Айл бүр хашаагаа мөрөг загасыг дүрсэлсэн хэд хэдэн даавуун далбаа хийсгэн чимэглэдэг.



## Охидын баяр

3-р сарын 3-ны өдөр эмэгтэй хүүхдийн өсөлтийг хүсэн ерөөж тэмдэглэдэг баяр юм. Гэр орноо эртний хувцастай эрэгтэй, эмэгтэй хүүхэддэйгээр чимэглэн тэмдэглэдэг.



## Хаврын өмнөх өдөр

2-р сарын 3-ны өдөр буюу хуучны тооллоор улирал солигдох мөчид чөтгөрийг хөөх арга хэмжээ болдог. Чөтгөрийн баг өмссөн хүн рүү шар буурцаг шидэж хөөн гаргаж, гэртээ аз жаргалыг дууддаг.

## Шинэ оны баяр

Шинэ оны эхний сарыг япон хэлээр “Шоогацу” гэдэг. Ихэнхи компани болон дэлгүүрүүд 3-ны өдөр хүртэл амардаг ба энэ үед шинэ он эхэлснийг тэмдэглэх олон арга хэмжээ болдог. Айлууд гэр бүлээрээ эрүүл мэндийг бэлгэдэн бэлтгэсэн тусгай хоол иддэг.



Хавар

Өвөл

Зун

Намар



## Од эрхсийн баяр

7-р сарын 7-ны өдөр нарийн хирчсэн өнгө өнгийн цаасан дээр өөрийн хүсэл мөрөөдлөө бичиж, хулсны мөчирт өлгөж хүсэл биелэх болтугай хэмээн залбирдаг. Зарим нутагт 8-р сард тэмдэглэдэг.



## Галын наадам

Зун болохоор томоохон гол, далай, нуурын эрэгт галын наадам зохион байгуулагдана. Зарим газар 1 цаг гаруй хугацаанд 5,000 орчим салютыг тасралтгүй буудуулж, үдшийн тэнгэрийг өнгө өнгөөр гэрэлтүүлдэг. Галын наадам нь Япончуудын хувьд зуны цагийн чухал арга хэмжээнүүдийн нэг юм.

## Тэргэл сарны баяр

Намрын тэргэл сартай үдэш тэмдэглэдэг баяр юм. Намар ургадаг “Сүсүки” гэдэг өвсийг чимэглэн, цагаан будааны нунтагаар хийсэн “Данго” гэх боовыг тэнгэрт өргөн барьж намрын шөнийн тэнгэрийг харан сууж баярлацгаадаг.



## Ургацын баяр

Цагаан будаа болон төрөл бүрийн ургац хураадаг намрын нэг өдөр ургацын баяр болдог. Бурхандаа талархал илэрхийлэхийн тулд түүний суудаг “Омикоши” дамнуургыг өргөцгөөн гудамж талбайгаар явна.





# Соёл



Япон баялаг соёлтой орон. Эрт үеэс дамжин ирсэн уламжлалт соёл ба анимэ, компьютерийн тоглоом гэх мэт орчин үеийн соёлын аль аль нь дэлхийн хэмжээнд танигдсан Япон улсын бахархалт соёл юм.

## КАВАИЙ

“Кавай” /хөөрхөн/ гэдэг үг бол дэлхийд танигдсан орчин үеийн Японы соёлыг илэрхийлэх түлхүүр үг юм. “Кавай” загвар бол дэлхийн залуучуудын гангарааны нэгэн түгээмэл загвар болдог.

## Анимэ

Сэтгэл хөдлөл, догдлолоор дүүрэн анимэ нь комикс, видео тоглоом зэргийг хөдөлгөөнд оруулсан бүтээл юм. Дэлхий даяар зурагтаар цацагдаж, кино театрын дэлгэцээр нийтэд танигдсан алдартай анимэ Японд олноор төрж байна.

## Видео тоглоом

Видео тоглоомоор ганцаараа ч, найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ ч тоглоход зугаатай. Видео тоглоомны шинэ шинэ төхөөрөмжүүд болон софтууд нь ар араасаа гарч, дэлхий даяар алдар цуутай болж байна.

## Зохиолын баатар

Төрөл бүрийн амьтан болон хүний өвөрмөц дүр төрх бүхий зохиолын баатрууд нь бичгийн хэрэгсэл, хувцас, хоол хүнсний боодол дээрх дизайн дөргөнөөр ашиглагдаж байгаа ба тэд үе дамжин олны танил болжээ.

## Караоке

Караоке нь дууны дан ганц аяыг нь тоглуулдаг төхөөрөмж юм. Микрофон барин түүнийг дагаж дуулбал мэргэжлийн дуучин болсон мэт сэтгэгдэл төрнө. Гэр бүл, найз нөхөдийн хамт цагийг зугаатай өнгөрүүлэх боломжтой.

## Косплэй

“Анимэ”-гийн гол дүрийн баатар болон алдартай зохиолын баатрын дүрд хувирахыг “косплэй” гэнэ. Сонирхогчид олноороо цуглан зургаа авахуулах дуртай.



## Ноо

Японд өвөрмөцөөр хөгжсөн үзүүлбэрийн урлагууд байдаг. Ноо бол хамгийн хуучны уламжлалт урлагийн нэг бөгөөд жүжигчин нь баг зүүн бүжиглэж, мөн дуу болон хөгжмийн зэмсгээр үлгэр домогийн ертөнцийг илэрхийлнэ.

## Шикки

Чийдсэн модон эдлэлийг “Шикки” гэх ба Англи хэлээр “JAPAN” гэж бас нэрлэдэг. Үндсэндээ аяга таваг гэх мэтийн өдөр тутмын хэрэглээний эд зүйлсийг хийдэг бөгөөд шаазан эдлэл, модон урлалтай нэгэн адил цэвэр урлагийн бүтээлийн хувьд ч хөгжиж ирсэн.

## Модон барилга

Японы уламжлалт барилга нь голдуу модоор баригдсан байдаг. Өвөрмөц хөгжил бүхий шилдэг технологиор баригдсан эдгээр барилгуудыг өнөөг хүртэл нандигнан маш сайн хадгалагдсаар ирсэн. Дэлхийн хамгийн хуучны модон барилга болох нэгэн сүм Японд одоо ч бий.

## Икэбана

16-р зууны үеэс уламжлагдан ирсэн “Икэбана” буюу цэцэг амьдруулах урлаг нь дөрвөн улирлын цэцэгсийг ашиглан тухайн улирлын төрхийг орон зайгаар илэрхийлдэг. Цэцгийг үзэсгэлэнтэйгээр амилуулахын тулд ур чадвар, байгалиа хайрлах философи шаардагддаг.

## Сүмо үзэх

Япон хүн спорт үзэх дуртай. Уламжлалт спорт болох “Сүмо”-гоо үзэн таалсан бөхөө дэмждэг.

## Үкиёэ

Үкиёэ бол 18-р зуунд хөгжсөн модон барын зураг юм. Европ маягийн зурагнаас огт ондоо зургийн энэхүү арга барил нь 19-р зууны Францын импрессионист зураачдад ихээр нөлөөлснөөрөө дэлхийд алдартай.



# Спорт



Японд бага настай хүүхдээс өдөр настай буурлууд хүртэл төрөл бүрийн спортоор хичээллэдэг. Би хөл бөмбөгт, манай эгч уран гулгалтанд дуртай. Миний өвөө Японд эртнээс уламжлагдаж ирсэн хэд хэдэн бүдоогоор хичээллэдэг.



## Сүмо

Сүмо бол 1000 гаруй жилийн түүхтэй Японы уламжлалт спорт юм. Барилдах бөхчүүд нь “Маваши” зүүж, “Мотодори” хэмээн нэрлэдэг эртний үс засалтыг хийлгэнэ.



## Жүүдоо

Жүүдоо нь олимпийн тэмцээний нэгэн төрөл болсон дэлхийд алдартай Японы уламжлалт спорт /бүдоо/ юм. Жүүдоогоос авахуулаад бүхий л төрлийн бүдоо нь ёс журмыг дээдлэн сэтгэлийн тэнхээг чангаруулахад гол анхаарлаа төвлөрүүлдэг.



скейтборд




загасчлал



бейсбол



Уран гулгалт



Давалгаан дээр гулгах



волейбол



Хөл бөмбөг



гольф



Маратон гүйлт



## Кюүдоо

Кюүдоо бол нум сумаар байг харваж онодог Японы уламжлалт бүдоогийн нэг юм. Анхаарлаа төвлөрүүлэхийг ихэд шаардах ба сэтгэлийн хаттай болгодог. Морь унангаа сум харвах төрөл ч бас бий.



## Кэндоо

Кэндоо нь эртний Самурай нарын хичээллэж ирсэн сэлэмний урлагийг үндэслэн хөгжсөн бүдоо юм. Хулсан сэлэм болон биеэ хамгаалах дуулга өмсдөг.



## Каратэ

Каратэ бол эртний Окинава аралд үүссэн бүдоо юм. Өрсөлдөгчөө нударгаараа цохиж, хөлөөрөө өшиглэдэг өвөрмөц хэв шинжийг агуулдаг.



# Түүх



Японы түүх 6 том үед хуваагддаг. Үе тус бүрийн онцлогийг тусгасан янз бүрийн өвөрмөц соёл хөгжиж ирсэн.



12-р зуун болоход цэргийн хүчээр давамгайл Самурайнууд улам хүчирхэгжиж, цэргийн засаглалыг тогтоож улс төрийг удирдсан. 15-р зууны сүүлийн хагас гэхэд Самурайнуудын бүлэглэл хоорондоо газар нутгийн төлөө дайтаж, дайн дажинтай байв.



Хүй нэгдлийн үед Япончууд ан агнуураар амьдардаг байсан бол яваандаа газар тариалан руу шилжиж нэг газраа тогтвортой суурьших болжээ. Суурин газрууд нь цаашлаад хэд хэдэн жижиг улс болж, улмаар том төр болж хөгжсөн.



**Ан агнуур ~ газар тариалан**

6-р зууны сүүл хүртэл



**Самурайн засаглал ~ Иргэний дайны үе**

13-р зуунаас  
16-р зууны сүүл

**Хуульт төрийн үүсэл ~ язгууртны соёлын үе**

7-р зуунаас  
12-р зууны сүүл



Эзэн хааны засаглалын дор хуульт төр бүрэлдэж, Киотод томоохон нийслэл хот байгуулагдаад язгууртны соёл цэцэглэн хөгжжээ.



Барууны улс орнуудын шаардлагаар Японы гадаад харилцаа нээлттэй болов. Самурайн засаглалийн үе дуусч, барууны тогтолцоо болон соёлыг нэвтрүүлсэн орчин үеийн төрт улс болж шинэчлэгджээ. Энэ хугацаанд дэлхийн дайнтай 2 удаа нүүр тулсан.

**Нээлттэй улс болох шинэчлэл ~ орчин үеийн төрт улс**

19-р зууны сүүлээс  
20-р зууны эхний хагас

**Дэлхийн II дайн ~ орчин үеийн нийгэм**

20-р зууны сүүлээс



**Энх тайван, тогтуун үе ~ Ард иргэдийн соёлын үе**

17-р зуунаас  
19-р зууны эхний хагас



Дэлхийн II-р дайн дууссаны дараа шинэ Үндсэн хуулиа батлаад ардчилсан төрт улс болов. Хүнд үйлдвэрлэл зэрэг аж үйлдвэрүүдийн үндсэн салбаруудыг хөгжүүлснээр эдийн засгийн гайхамшигтай өсөлтөнд хүрч, дэлхийн улс орнуудтай төрөл бүрийн хамтын ажиллагаагаа өрнүүлж байна.



Иргэний дайны дараа Эдо буюу одоогийн Токиод Самурайн засгийн газар байгуулагдаж, 300 орчим жил энх тунх байдал үргэлжлэв. Энэ үед энгийн ард иргэдийн соёл хөгжсөн боловч, гадаад харилцааны хувьд ямар ч улс оронтой харьцахгүй гэсэн бодлого явагдаж байсан.



# Төр засгийн тогтолцоо, Олон улсын харилцаа



Япон улс Үндсэн хуулиараа Парламент, Засгийн газар, Шүүх гэсэн гурван бие даасан засаглал харилцан хяналт тавьж, тэнцвэртэй байдлыг хадгалснаар эрх мэдлийг урвуулан ашиглахаас сэргийлж, иргэдийн үндсэн эрх ба эрх чөлөөний баталгаа болгох “Төрийн 3 эрх мэдлийг хуваарилах” зарчмыг баримтладаг.

## Олон улсын харилцаа



Дэлхийн энх тайван ба олон улсын нийгэмлэгийн тогтвортой байдлыг хангахын тулд Япон улс НҮБ-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, өөрийн үүргээ гүйцэтгэж ирсэн. Мөн хоёр талын харилцаа төдийгүй, G8, G20 болон бүс нутгийн хамтын ажиллагаа зэрэг төрөл бүрийн хэлбэрээр дэлхийн улс орнуудтай хамтран ажиллаж байна.



**Байгаль орчин, цаг уурын өөрчлөлт**  
Япон нь дэлхийн дулаарлын шалтгаан болох хүлэмжний хийг багасгах зорилго бүхий дүрэм бий болгохоор дэлхийн улс орнуудад уриалсаар ирсэн. 1997 онд батлагдсан “Киотогийн протокол” нь үүний нэг үр дүн юм.



**Зээл тусламж, яаралтай тусламж**  
Япон нь хөгжиж буй орнуудын нөхцөл байдалд тохируулан хөнгөлттэй зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэх, техник технологио шилжүүлэх зэрэг шаардлагад нийцүүлэн төрөл бүрийн дэмжлэгийг үзүүлдэг. Мөн гадаадад гамшиг тохиосон үед өөрсдийн туршлагад тулгуурлан төрөл бүрийн тусламж үзүүлж байна.




**Энхийн сахиулах, терроризмын эсрэг**  
Олон улсын аливаа маргааныг шийдвэрлэж, энх тайвныг бий болгохын тулд Япон НҮБ-ийн Энхийг сахиулах үйл ажиллагаанд хүн хүч илгээх, эд материалаар хангах гэх мэтээр идэвхтэй ажиллаж байна. Мөн бусад улс оронтой хамтран терроризмын эсрэг үйл ажиллагаагаа явуулж байна.



**Соёлын солилцоо**  
Японы талаар илүү ихийг таниулж, нөхөрсөг харилцааг бий болгохын тулд Япон дэлхийн улс орнуудад өөрийн соёл болон нийгмийн байдлыг танилцуулж, мөн хүний солилцоогоор дамжуулан харилцан ойлголцлыг улам гүнзгийрүүлж байна.

Хууль  
ТОГТООХ  
засаглал



## Парламент

Парламент бол хууль тогтоох байгууллага юм. Төлөөлөгчдийн танхим /Доод танхим/ болон Зөвлөхүүдийн танхим /Дээд танхим/ гэсэн хоёр танхимаас бүрддэг ба сонгуулиар иргэдийн сонгосон гишүүд Парламентийн ордонд үйл ажиллагаагаа явуулдаг.

Сонгууль

Гүйцэтгэх  
засаглал

Иргэдийн  
санал

Иргэн

Огцруулах  
эсэхийг  
шийдэх

Шүүх  
засаглал



**Засгийн газар**  
Засгийн газар нь Парламентийн шийдвэрийн дагуу бодлого хэрэгжүүлдэг байгууллага юм. Ерөнхий сайд болон төрийн ажлын салбар тус бүрийг хариуцах Төрийн сайдуудаас бүрддэг.



Шүүх

Шүүх нь иргэний эрхийг хамгаалж, аж амьдралын тайван, аюулгүй байдлыг хамгаалахын тулд Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэж, гэмт хэрэгт сэжигтэн хүний буруутай эсэхийг шалган тогтоодог байгууллага юм.



# Эдийн засаг, аж үйлдвэр, техник технологи



Япон нь дэлхийн хамгийн өндөр хөгжилтэй орнуудын нэг юм. Энэ хуудсанд аж үйлдвэрийн салбарт дэлхийн хэмжээний төлөөлөл болсон хэд хэдэг шилдэг технологийг танилцуулъя.



## Японы эдийн засгийн хүчин чадал

Япон боловсруулах аж үйлдвэр маш өндөр хөгжсөн боловч, байгалийн нөөц багатай тул гадаад худалдааны хувьд төрөл бүрийн түүхий эд импортлож, бүтээгдэхүүнээ экспортлодог. Аж үйлдвэрийн үндсэн салбар нь автомашин, механик, тоног төхөөрөмж, компьютер, гэр ахуйн цахилгаан барааны үйлдвэрлэл бөгөөд шилдэг технологи болон шинэлэг санаа нь эдийн засгийн хөгжлийг жолбодож байна.



### Супер компьютер

Японд бүтээсэн супер компьютер болох "Кэй" нь 1 секундэнд  $10^{16}$  үйлдэл хийх чадвартай дэлхийн хамгийн өндөр түвшний компьютер юм. Эрчим хүчийн шинэ эх үүсвэрээ нээх, анагаах ухаан болон гамшгаас урьдчилан сэргийлэх зэрэг салбарт ашиглагдахаар төлөвлөгдсөн байна.



### Шинкансэн

Шинкансэн бол цагт 200 км-ээс дээш хурдтайгаар зорчих төмөр замын систем юм. Зүүн хойд бүс нутагт зорчих "Хаябүса" нь Японд хамгийн хурдан буюу цагт 320 км хурдалдаг галт тэрэг юм. Бүх шинкансэн тав тухыг бүрэн хангаж, аюулгүй байдлыг өндөр түвшинд хадгалсаар ирсэн.



### Аюулгүй автомашин

Японы автомашин аюулгүй байдлаараа дэлхийд нэгдүгээрт ордог бөгөөд хамгийн найдвартай нь. Ослоос сэргийлэхийн тулд мотор болон тормозыг автоматаар удирдах системээс эхлээд олон төрлийн дэвшилтэт функцээр хангагдсан байдаг. Өдгөө ослын үеийн хохирлыг багасгаж, хүний амийг хамгаалах автомат жолоодлогын системийг бүтээхэд анхаарлаа хандуулж байна.



### Асрагч робот

Японд яг хүн шиг хөдөлдөг роботын технологи хөгжиж байгаа билээ. Үйлдвэр болон барилгын талбай гэх мэт аж үйлдвэрийн талбар дээр роботын эрэлт хэрэгцээ ихэсч байгаагийн зэрэгцээ өндөр настнуудыг асрахад роботын хүчийг ашиглахаар судалгаа, туршилт явагдаж байна.



### Авсаархан дижитал аппарат

Японы дижитал зургийн аппарат нь авч явахад амар, хөнгөн авсаархан болсоор байна. Хэдий жижиг боловч чадамж нь маш гайхалтай. Ашиглахад амархан ба зургийн аппаратны талаар мэдлэггүй байсан ч сайхан зураг авч чадна.

## Хөдөө аж ахуй, Загасны аж ахуй



Японы хөдөө аж ахуйн салбарт цагаан будаа, хүнсний ногоо, жимс тариалалт голлох бөгөөд мал аж ахуй, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, загасны аж ахуй ч мөн өндөр хөгжсөн. Гэвч Японы хүн ам их тул өөрийн хүнсний хэрэгцээг хангах үзүүлэлт доогуур гардаг ба олон төрлийн хүнсний бүтээгдэхүүн болон түүхий эдийг гадаадаас импортлодог.

## Иен



Японы мөнгөний нэгж болох "Иен" бол дэлхийн эдийн засагт шууд нөлөөлөх хүчтэй валют юм. 10,000, 5,000, 2,000, 1,000 иений цаасан дэвсгэрт болон 500, 100, 50, 10, 5, 1 иэний зоос байдаг бөгөөд хуурамчаар хийснээс ялгахын тулд маш нарийн дизайнтай хийгдсэн байгаа.



# Байгаль орчны хамгаалал

Япон нь дэлхийн байгальд ээлтэй амьдралыг хэрэгжүүлж, төрөл бүрийн арга хэмжээ авч байна. Хязгаарлагдмал нөөцөө нандигнаж, бид ч мөн өөрсдийн чадах бүхнийг идэвхтэй хийж байна.

## Дахивар

Хэрэглэж дууссан хуванцар сав болон хуучин цаас, хувцсаа хаялгүйгээр шинэ бүтээгдэхүүн хийх түүхийг эд болгон ашиглана.

## Дахин ашиглах

Дахин ашиглаж болох савыг хаялгүйгээр доторхыг нь сольж дахин ашиглана. Юм эвдэрвэл засч янзлаад хэрэглэж, мөн багадсан хувцсаа хаялгүй хэрэгтэй хүнд өгнө.

## Хаягдал багасгах

Гэр ахуйн хог хаягдлыг багасгахын тулд дэлгүүр явахдаа тороо авч явах, хэт олон давхар боодол бүхий бүтээгдэхүүн худалдаж авахгүй байхыг хичээдэг.

## “Моттайнай”


Япон хэлэнд “Моттайнай” буюу “хайран юм” гэдэг үг байдаг. Эд зүйлийг гамтай хэрэглэж, шаардлагагүй хэрэгцээг багасгах гэсэн байгаль орчин хамгааллын зорилтыг шууд илэрхийлэх үг учраас дэлхий нийтээр энэ үгийг хэрэглэх хөдөлгөөн өрнөж байна.

## Ногоожуулалт

Устсан ой модыг сэргээхийн тулд сүйдсэн уулыг моджуулах, хотыг цэцэрлэгжүүлэн гудамжинд мод тарих, барилгын дээврийг ногоожуулах зэрэг төрөл бүрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

## Ухаалаг хаус

Байгаль орчинд ээлтэй амьдралыг бий болгохын тулд хаус дотор эрчим хүчний үүсгүүр байрлуулж түүнийгээ удирдах боломжтой шинэ үеийн сууцыг бүтээх судалгаа явагдаж байна.



## Нарны зай

Нарны туяа нь эрчим хүчний шинэ эх үүсвэр болдоороо олны анхаарлыг татаж байна. Хувийн сууц, бүхэл бүтэн хот суурин газрыг дан нарны хураагуураар үүсгэсэн цахилгаанаар хангах зэрэг сэргээгдэх эрчим хүчийг амьдралд ашиглах боломжийг судалж байна.

## Нарны зайгаар явдаг автомашин

Нарны үүсгүүрээр гаргасан цахилгаанаар явдаг автомашин нь нүүрсхүчлийн хий ялгаруулахгүй, байгаль орчинд ээлтэй тул энэ технологийг бодит хэрэглээ болгох судалгаа Японд ч бас явагдаж байна.

## Оффисийн сэрүүн орчин

Оффист ажиллах эрэгтэй хүн зуны улиралд ч костюм пиджак, зангиа зүүж байсан бол, сүүлийн үед зангиа зүүхгүй, хагас ханцуйтай цамцтай ажлаа хийдэг болсноор агааржуулагчийн хэрэглээ багасаж, эрчим хүчний зарцуулалт буурсан үр дүн гарч байна.



## Хаягдлын дулааныг ашиглах


Айл өрхөөс гарах хог хаягдлыг хог боловсруулах үйлдвэрт шатаадаг. Энэ үед үүсэх дулааныг бассейны усыг халаах эх үүсвэр болгон ашиглах зэрэг эрчим хүчийг илүү үр ашигтай зарцуулах арга хэмжээ авдаг.



Хог хаягдал



Хог боловсруулах үйлдвэр



Бассейн

